

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар



**АУДИТЫН ХУРААНГУЙ
ТАЙЛАН**

ХЭА-2023/19-22-ШТА-ГА

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ, ҮР ДҮНД
СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО,
ҮР НӨЛӨӨ**

**ЭРҮҮЛ МЭНДИЙН
ДААТГАЛЫН ГҮЙЦЭТГЭЛД
СУУРИЛСАН
ТОГТОЛЦООНД
ШИЛЖСЭНЭЭР ИРГЭД
ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ
ТҮРГЭН ШУУРХАЙ,
ЧАНАРТАЙ АВАХ НӨХЦӨЛ
БҮРДСЭН ХЭДИЙ Ч
ИРГЭДИЙН ДААТГАЛД
ХАМРАГДАЛТ ХАНГАЛТГҮЙ
БАЙНА.**

Хэрлэн сум
2023 он



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын сэдэв: “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө”

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны 09 дүгээр тогтоолын дагуу Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/04 дугаар тушаалаар баталсан аудитын сэдвийн хүрээнд хийнэ.

АУДИТЫН ГОЛ ДҮГНЭЛТ:

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦҮҮЛЭН
ТӨЛӨВЛӨЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОЛОВЧ ДОТООД ХЯНАЛТ
ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

Тайланг хүргүүлсэн этгээд: Үндэсний аудитын газар, Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, аймгийн Засаг дарга

Нэмэлт мэдээлэл, мэдээллийн эх сурвалж: QR кодыг байршуулах, эргэх холбоо, санал авах болон мэдээлэл, хүсэлт, хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар харилцах албан ёсны хаяг:

Хэнтий аймаг, Хэрлэн сум, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар, e-mail: khentii@audit.gov.mn, Утас:7056-2112

Чингис хот

2023 оны 5 дугаар сарын 20

Аудитын харилцан хамаарал: (Сэдвийн ач холбогдол болон аудит хийх болсон шалтгаан нөхцөл байдал болон хүлээгдэж буй эрсдэлийн тухай бичнэ.)

- Аудитыг хийснээр ЭМ-ын салбарын тогтолцоо сайжрах, эрүүл мэндийн байгууллагуудад санхүүжилтийн хүндрэл үүсэхгүй байх, бие даан ажиллах боломж бүрдэх бөгөөд иргэдэд хүрэх эрүүл мэндийн үйлчилгээ сайжирна.
- Харин баримт материал дутуу байх, цаг хугацаанд нь мэдээллээ цахим санд оруулахгүй байх, үзүүлсэн үйлчилгээний төлбөрөө авч чадахгүй байх, боловсон хүчний дутагдалд орох, санхүүгийн хувьд алдагдалтай ажиллах, ажлын ачаалал хэтрэх зэргээр үйл ажиллагаа доголдож, иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээ доголдож болзошгүй байна.
- Аудитыг давтан хийсний дүнд зөрчил буурна.

Аудитын зорилго, зорилтууд, хамарсан хүрээ: (Аудитын зориулалт болон аудитыг хийснээр юунд хүрэхэд чиглэгдэж байгаа болон хамрах хүрээнд аудитад хамрагдсан байгууллага, төсөл, хөтөлбөр, цаг хугацаа, байршлууд зэрэг аудитын хязгаарын талаар товч мэдээлэл)

- Аудитыг хийснээр ЭМД-ын тогтолцоо нь эрүүл мэндийн салбарын байгууллагууд болон иргэдэд үр өгөөжөө өгч байгаа эсэхэд үнэлэлт өгч зөрчил дутагдлыг засахад чиглэгдэнэ.
- Аудитад аймгийн ЗДТГ, аймгийн ЭМГ, аймгийн ЭМДХ болон 17 сум 4 тосгон, 4 өрхийн эмнэлэг зэрэг анхан шатны 25 ЭМТ, лавлагаа шатлалын 3 эмнэлэг, 40 эмийн сан,
- Аудитад ЭМД-ын санхүүжилтээр 2021-2022 онд санхүүжүүлсэн санхүүжилтийн гүйцэтгэл, орлогын төлөвлөлт болон энэ талаар гарсан хууль эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг хамрууллаа.

Аудит хийхэд гарсан хүндрэл бэрхшээл: (Аудит хийхэд ямарваа нэгэн хязгаарлалт үүссэн бол бичнэ.)

- Аудитууд давхардсанаас энэхүү аудитад зарцуулах цаг хугацаа, хүний нөөц хомс байлаа.

Аудитын гол үр дүн: (Тоон болон чанарын хувьд материаллаг илрүүлэлт бүхий асуудлын талаар бичнэ.)

БҮЛЭГ 1. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн тогтолцоог орон нутгийн эм, эмнэлгийн байгууллагууд мөрдөж ажиллаж байна.

- **А.1.** Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн тогтолцоог орон нутгийн эм, эмнэлгийн байгууллагууд мөрдөж ажиллаж байна.

Эрүүл мэндийн салбарыг даатгалаас санхүүжүүлэх тогтолцоонд шилжиж байгаатай холбоотой "Монгол улсын Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг сайжруулах төсөл" 2019-2022 онд салбарын яам болон Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт хэрэгжиж, эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцооны шинэчлэлийг эхлүүлсэн байна. Мөн ЭМДҮЗ-өөс тусламж үйлчилгээний жагсаалт, төлбөрийн хэмжээг баталж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх

байгууллагыг сонгон шалгаруулах, боловсон хүчнийг чадавхжуулах ажлуудыг зохион байгуулж, холбогдох хууль, тогтоомжуудыг боловсруулан гаргасан байна.

БҮЛЭГ Б: Эрүүл мэндийн байгууллагууд санхүүжилтийн хувьд бие даасан байдалд шилжсэнээр ахиц дэвшил гарч байгаа ч боловсон хүчний дутагдал, эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт, тасалдалт зэрэг шийдвэрлэх асуудлууд байна.

➤ **Б.1. ЭМД-ыг өөрөө төлөгч иргэдийн даатгалд хамрагдалт хангалтгүй, санхүүжилтийн нэхэмжлэлийг журмын дагуу хянаж олгож байгаа ч урьдчилгааг гэрээнд заасан хугацаанд олгохгүй байна.**

ЭМД санд 2021 онд Хэнтий аймгийн ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн 5,172.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 106.3 хувиар, ЭМД-ын шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг иргэний шимтгэлийн 530.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 123.6 хувиар биелүүлсэн бол 2022 онд Хэнтий аймгийн ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн 6,548.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 66.9 хувиар, ЭМД-ын шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг иргэний шимтгэлийн 617.2 сая төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөөг 70.5 хувиар тус тус биелүүлсэн байна.

Эрүүл мэндийн салбар гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнээр Хэнтий аймгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг анхан шатны болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудад 2021 онд 21,759.3 сая төгрөгийн санхүүжилт авч 2020 онтой харьцуулахад 2021 онд 14.2 хувь, 2022 онд 26,573.6 сая төгрөгийн санхүүжилт авч 39.5 хувь тус тус өсжээ.

Эрүүл мэндийн байгууллагуудын худалдаж авсан эмнэлгийн зориулалттай үндсэн хөрөнгийг 2020 онтой харьцуулахад 2021 онд 32.7 хувиар буурсан, 2022 онд 57.7 хувиар өссөн нь эрүүл мэндийн тусгай шаардлага бүхий тоног төхөөрөмжийг худалдаж авснаар иргэд, даатгуулагчдад үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар дээшилхэд нөлөөлж байна.

Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг өөрөө хариуцан төлдөг иргэдийг даатгалд хамруулах ажил 2021 7394 даатгуулагчийг хамруулж 53 хувиар, 2022 онд 8986 даатгуулагчийг хамруулж төлөвлөгөө 69.0 хувиар тус тус биелүүлснийг аймгийн 2021-2022 оны статистик мэдээтэй харьцуулахад 2021 онд 8120, 2022 онд 7851 иргэн эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй үлдсэн байна.

Энэ нь ЭМД-д иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах НДХ болон ЭМД-ын хэлтсийн хоорондын ажлын уялдаа хангалтгүй байгаа, хуулийн зохицуулалт оновчгүй байгаа нь ЭМД-д хамруулах төлөвлөгөө хангалтгүй биелэхэд нөлөөлж байна.

ЭМДЕГ-аас 2021 онд өрх, сум, тосгон, лавлагаа шатлал, рашаан сувилал, эмийн сан зэрэг 70 байгууллагын гэрээг дүгнэж 19 байгууллага дүгнэгдээгүй, 2022 онд 35 байгууллагын гэрээг дүгнэж 35 байгууллагын гэрээг дүгнээгүй байна.

➤ **Б.2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх тогтолцооны**

хүрээнд салбарын байгууллагууд цахим системд бүрэн шилжсэн байна.

ЭМДЕГ-ын цахим систем болох health.gov.mn-ыг хөгжүүлэн ашиглаж байгаа ба 13А маягтыг цахимаар илгээх, хүлээн авах, иргэд төрийн үйлчилгээний нэгдсэн систем "E-Mongolia"-аас харах нөхцөл бололцоог бүрдүүлсэн, Н-info программыг бүх эрүүл мэндийн байгууллага, e-health программыг аймгийн болон Бор-Өндөр сумын эмнэлэг, e-hospital программыг анхан шатны 25 эрүүл мэндийн байгууллага, health.gov.mn-ыг бүх эрүүл мэндийн байгууллага өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Өнгөрсөн 2022 онд орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн нийт 24.4 сая төгрөгийн 14 ширхэг компьютер, киоск машиныг аймгийн Нэгдсэн эмнэлэгт ашиглалтад оруулж иргэд үзлэгийн цаг авах болон лабораторийн шинжилгээг хүлээгдэлгүй авах боломж бүрдсэн, 4 өрхийн ЭМТ-д олгосон ба цахим программ хангалт /e-health/ ашиглалт 75 хувьтай байна.

Аймгийн ЭМДХ 2022 онд 7 иргэний өргөдлийг бичгээр хүлээн авч шийдвэрлэсэн, төрөөс эрүүл мэндийн төлбөрийг хариуцдаг нийт 191 иргэний даатгал төлөлтийн тасарсан хугацааны засварыг хийж үйлчилсэн, лавлах утас 70562001 дугаараар иргэдэд эрүүл мэндийн даатгалтай холбоотой лавлагаа, зөвлөмжийг тогтмол өгч ажиллаж байна.

➤ *Б.3. Эрүүл мэндийн даатгалын салбарын хяналт шалгалт, дотоод аудитыг хэрэгжүүлэн ажилласан байна.*

ЭМДҮЗ болон аймгийн ЭМД-ын хэлтсээс жил бүр гүйцэтгэлийн шалгалтыг зохион байгуулж илэрсэн зөрчилд төлбөрийн акт тавих, зөвлөмж өгөх зэргээр алдаа зарчлийг давтан гаргуулахгүй байх тал дээр анхаарал хандуулан ажилласан байна.

2021 онд нийт 11 эрүүл мэндийн тусламж үйлчилгээг давхардсан тоогоор 343482 иргэний 23,513.6 сая төгрөгийн нэхэмжлэлийг шалгаж 336949 иргэний 21,821.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 6533 иргэний 1,692.1 сая төгрөгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг хассан байна.

Харин 2022 онд 13 эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрлөөр 347027 иргэний 29,785.6 сая төгрөгийн нэхэмжлэлийг шалгаж 336882 иргэний 27,668.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 10145 иргэний 2,166.7 сая төгрөгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг хассан байна.

Нийт хасагдалд эмчийн хасагдал 23.3 хувь, цахимын хяналтын хасагдал 74.6 хувь, их олонлогийн хасагдал 2.1 хувийг эзэлж байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

(Аудитын илрүүлэлтэд үндэслэн аудиторын зүгээс гаргаж буй мэдээгдэл)

- Эрүүл мэндийн салбарт ЭМД-ын тухай хууль хэрэгжиж, цахим системд бүрэн холбогдсоноор иргэдэд хүргэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ сайжирч, ЭМБ-ууд бие даан үйл ажиллагаа явуулахад дэвшил гарсан байна.

- ЭМД-ын шимтгэлийн орлогын төлөвлөгөө болон малчин, оюутан, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын төлөвлөгөөг бүрэн биелүүлээгүй байна.
- Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь батлагдсан хүний нөөцийн хүрээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг журмын дагуу хянаж, санхүүжилтийг олгож байгаа ч нэхэмжлэлийн хяналтын хасагдлын мэдээлэл, зөвлөмжийг эрүүл мэндийн байгууллагуудад бүрэн хүргүүлэхгүй байна.
- Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын сонгон шалгаруулалт, гэрээ байгуулах үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулдаггүй байна.
- ЭМДЕГ-аас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч лавлагаа болон анхан шатны 30 байгууллагатай байгуулсан 2022 оны даатгалын гэрээг дүгнээгүй байна.
- Анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх өрх, сум, тосгоны ЭМТ болон эмийн хөнгөлөлт үзүүлэх хувийн хэвшлийн эмийн сангуудад даатгалын гэрээний дагуу даатгуулагчдад үзүүлэх тусламж, үйлчилгээний урьдчилгаа олгодоггүй байна.
- Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжлийн ажиллах хүчний дутагдал, эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах ажиллагааг аймгийн ЭМГ-т зохион байгуулж хуваарилдгаас шалтгаалан эм тарианы тасалдал үүсэж байгаа зэрэг нь тусламж, үйлчилгээний чанар, төрөл, гүйцэтгэлийн санхүүжилтэд сөргөөр нөлөөлж байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ:

(Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийг арилгах, засаж сайжруулах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөгөө, санал)

Аймгийн Засаг дарга Ц.Чогсомжав-д:

- Сумдын ЭМТ нь гүйцэтгэлээр санхүүжиж байгаа тул эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авах ажиллагааг ил тод, нээлттэй зохион байгуулах боломжийг судалж шийдвэрлэх;

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Н.Нямхатан-д:

- ЭМД-ын шимтгэлээ өөрөө хариуцан төлөх иргэдийг даатгалд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах;

Аймгийн Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Доржханд-д:

- Анхан шатны ЭМБ-ын мэргэжлийн боловсон хүчнийг төлөвлөх, сургах, урамшуулах замаар хэрэгцээт хүний нөөцөөр хангах бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх;

Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга С.Хэнчмэдэхгүй-д:

- Анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх өрх, сум, тосгоны ЭМТ болон эмийн хөнгөлөлт үзүүлэх хувийн хэвшлийн эмийн сангуудад даатгуулагчдад үзүүлэх тусламж, үйлчилгээний урьдчилгаа төлбөрийг гэрээний дагуу тогтсон хугацаанд олгож байх;
- Эрүүл мэндийн байгууллагуудад нэхэмжлэлийн хасагдлын мэдээллийг холбогдох журмын дагуу бүрэн хүргэж ажиллах;
- Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын даатгалын гэрээний биелэлтийг “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээний

биелэлтийг үнэлэх, урамшуулал олгох журам"-ын 2.1 дэх заалтад заасан хугацаанд дүгнэж байх;

ХАВСРАЛТ:

(Аудитын явцад илэрсэн зөрчил дутагдлын нэгтгэл, алдаа, зөрчлийг арилгах, давтан

ХАВСРАЛТ 1: Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл